



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/05

Дадал сум

Цэцэрлэгийн өмч хамгаалах байнгын
Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.11, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.1, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын арван нэгдүгээр хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Цэцэрлэгийн өмч хамгаалах байнгын Зөвлөлийг (ажлын хэсэг) дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч:	Д.Оюунгэрэл (Бүлгийн багш)
Зөвлөлийн нарийн бичиг:	Ж.Мөнхзул (Нягтлан бодогч)
Гишүүд:	Д.Доржханд (Бүлгийн багш)
	Д.Отгонцэцэг (Багшийн туслах)
	Б.Эрдэнэчимэг (Гал тогооны туслах)

2. Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль төрийн өмчийн тогтоолоор батлагдсан журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Зөвлөлийн ахлагч (Д.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/16 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЭРХЛЭГЧ



Н.ОДГАРАВ